

“БУЛГАН-УНДАРГА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 дүгээр сарын 27 өдөр

Дугаар № 18/02

Булган хот

САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТЭНЦЛИЙН ДҮН, НОГДОЛ АШГИЙН ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Булган-Ундарга” ХК-ийн 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Булган-Ундарга” ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн хийсэн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2017 оны үйл ажиллагааны байдлыг харгалзан энэ онд ногдол ашиг олгохгүй байхаар тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА:



Б.БАЙГАЛМАА

“БУЛГАН-УНДАРГА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 дүгээр сарын 27 өдөр

Дугаар № 18/03

Булган хот

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дэх заалт, 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн “Булган-Ундарга” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Булган-Ундарга ХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд Батаа овогтой Төгсбуянг томилон ажиллуулсугай.
2. Хуулийн хугацаанд Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж өөрчлөлт оруулсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:



Б.БАЙГАЛМАА

Д.АМГАЛАН

Б.ТӨГСБУЯН

“БУЛГАН-УНДАРГА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 дүгээр сарын 27 өдөр

Дугаар № 18/04

Булган хот

Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.1-д заасныг үндэслэн “Булган-Ундарга” ХК-ийн 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн тогтоох нь:

1. “Булган-Ундарга” ХК-ийн дүрмийг шинэчилэн өөрчлөлт оруулж, компанийн дүрмийн эхийг хавсралтаар баталгаажуулсугай.
2. Компанийн дүрмийн шинэчилсэн өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хуулийн хугацаанд бүртгүүлж, хувийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг гүйцэтгэх захирал /Б.Төгсбуян/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:



Б.БАЙГАЛМАА

Д.АМГАЛАН

Б.ТӨГСБУЯН